



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.04.29 № 19

Хуулийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийг баталсан.

Энэхүү хуулиар малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс болон тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулснаас гадна малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд малчдын оролцоог хангах, малчин өрхийн холбооны тогтолцоог өөрөө удирдах ёсны зарчимд нийцүүлэн зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Гэвч хөдөө, орон нутагт ажиллаж байх явцад энэ хуулийн хэрэгжилт төдийлөн хангалттай бус, малчин өрхийн холбоодын мэдээлэл малчдад ил тод биш байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Малчин өрхийн анхдагч, сумын, аймгийн, нэгдсэн холбооны тогтолцоо бүрдсэн эсэх, уг холбоонд элссэн малчин өрхийн тоо, гишүүнчлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2. Дээрх тогтолцооны дагуу тухайн шатны төрийн бодлого үйл ажиллагаанд малчин өрх, малчдын холбооны эрх ашгийг хангаж, төрийн үйлчилгээ, зээл, санхүүгийн хүртээмж нэмэгдэж байгаа эсэх талаар;

3. Энэхүү хууль хэрэгжиж эхэлснээр малчдын нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах, боловсрол эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, малчдын залгамж халаа бэлтгэх, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, өвлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, түүний явц, үр дүнгийн талаар;

2025000028

4. Хууль хэрэгжиж эхэлснээр малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, түүний чанарыг сайжруулах, нийлүүлэлтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр гарч буй үр дүн;

5. Бэлчээрийг гэрээгээр ашиглах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, сэлгэх нүүдэллэх, бэлчээрийг нөхөн сэргээх чиглэлээр гарч буй ахиц, үр дүнгийн талаар;

6. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах харилцааг төлөвлөх, шийдвэр гаргах, гэрээ байгуулах, гэрээг бүртгэх, дүгнэх, бэлчээрийг зохистой ашиглах чиглэлээр тус хуулиар хүлээсэн үүргээ төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж байгаа байдал, тулгамдаж байгаа асуудал, бэлчээрийн ашиглалт, түүний үр дүнгийн талаар;

7. Хууль хэрэгжиж эхэлснээр нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын зүгээс малчдын холбооны эрх ашгийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнгийн талаар зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



Ж.БАТЖАРГАЛ

2025000028